

ОХУ-ЫН ИННОВАЦИЙН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ: АГУУЛГА БОЛОН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

*Ж.Орхон**

Оршил

Хэдийгээр дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн боловч өнөөгийн эдийн засгийн шинж төлвийг мэдлэгт суурилсан, мэдлэг, ур чадвар, мэдээллийн хурдын өрсөлдөөн давамгайлсан эдийн засаг гэж тодорхойлж болох юм. Иймээс мэдлэгийн хүч, бүтээх чадвар бол эдийн засгийн хөгжлийн гол хөдөлгөгч хүч нь болж байна. Мэдлэгт суурилсан эдийн засаг гэдэг нь мэдлэгийг бүтээх, олж авах, эзэмших, дамжуулах, хэрэглэх, хөгжүүлэх нөхцөл боломж, чадавхийг бүрдүүлсэн эдийн засаг юм. Үүнийг бий болгох, төлөвшүүлэх үндсэн арга зам бол үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх явдал билээ. Өөрөөр хэлбэл мэдлэгт суурилсан эдийн засаг гэдэг бол инновацийг хөгжүүлсэн эдийн засаг юм.

Инноваци гэдэг нь шинэ зүйлд хөрөнгө оруулах “investment in novation” гэсэн утгатай үг. Иймээс зах зээлийн өнөөгийн нөхцөлд инноваци ба хөрөнгө оруулалт гэсэн ойлголтууд нь өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой. Новаци буюу өөрчлөлт, шинэчлэлт гэж өмнө нь байгаагүй шинэ зүйлийг хэлдэг. Тиймээс энэхүү шинэ бүтээл, технологийг зах зээлийн эргэлтэнд оруулах асуудал бол инновацийн үндсэн агуулга болно.

Инновацийг илүүтэй анхаарч, төрийн бодлогоор дэмжсэнээр улс орноо хөгжлийн өндөр түвшинд хүргэсэн, улмаар иргэдийнхээ амьдралын түвшинг эрс дээшлүүлж чадсан улс орон олон байдгаас Өмнөд Солонгос, Нидерланд, Канад, Англи, АНУ, Швед, Франц, Япон, Герман, Австрали улсууд дэлхийд эхний аравт ордог. Өмнөд Солонгос улсын хувьд технологийн инновацид ач холбогдол өгч чадсанаар эдийн засагаа хөгжлийн өндөр түвшинд хүргэсэн. 1960-аад оны үед дэлхийн хамгийн ядуу буурай орны нэг байсан бол технологи дамжуулалтыг төрийн бодлогоор дэмжиж, гадаадаас оруулж ирсэн технологийг өөрчлөн шинэчлэх замаар дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлж чадсан юм.

ОХУ-ын инновацийн хөгжлийн үйл явц

ОХУ-ын хувьд 1992 оноос зах зээлийн эдийн засагт шилжснээр зах зээлийн маягийн цоо шинэ үндэсний инновацийн тогтолцоог төлөвшүүлж эхэлсэн. Дэлхийн эдийн засгийн форумын жил тутмын мэдээгээр ОХУ өрсөлдөх чадварын өсөлтийн индексээр 2001 онд 80 орны дотор 63-р байранд орж байсан бол 2002 онд 64-т, 2003 онд

* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

65-д жагсжээ. Гэвч инновацийн хөгжилд тушаа болж буй зүйл нь Орос улсад одоо хуучин захиргаадалтын үеийн инновацийн тогтолцооны зарим шинж зах зээлийн эдийн засгийн үеийн үндэсний инновацийн тогтолцооны шинэ элементүүдтэй хосолсон шилжилтийн маягийн тогтолцоо үйлчилж байгаатай холбоотой байна.

Хуучин тогтолцооны гэдэгт ихэнх шинжлэх ухаан-техникийн байгууллагыг багтааж байгаа бол зах зээлийн тогтолцооныход аж үйлдвэр, үйлчилгээний хүрээнд ажиллаж буй хувийн хэвшлийн шинжлэх ухаан-техникийн байгууллага, инновацийн жижиг үйлдвэр, төрийн бус эрдэм шинжилгээний аналитик, консалтингийн болон арилжааны бус олон тооны төв багтаж байна.

ОХУ үндэсний инновацийн тогтолцоог бий болгох зорилтыг тус орны хөгжлийн стратеги зорилт, түүний дотор шинжлэх ухаан-технологийн хүрээний стратеги болгон 1997 оноос төрийн бодлогын түвшинд тунхагласан. Оросын инновацийн хөтөлбөр нь Холбооны улсуудын инновацийн зорилтот хөтөлбөрүүд, томоохон инновацийн төслүүд, инновацийн үйл ажиллагааг дэмжих, инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх холбооны улсуудын хөтөлбөрүүдээс бүрддэг.

Инновацийн тогтолцооны бие даасан элементүүд болох улсын сан, технопарк, инноваци-технологийн төв, инновацийн төслийн санхүүжилтийн сан зэрэг бий болов. Инновацийн хүрээнд шинэ бүтээл туурвих, арилжаанд оруулах бүтцийг бий болгох, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх эдийн засгийн үр ашигтай механизм бүрдүүлэх талаар тодорхой туршлага хуримтлуулаад байгаа билээ.

Удаан хугацааны стратегийн төлөвлөгөө гаргахын тулд дэлхийн эдийн засгийн хөгжлийн удаан хугацааны бодит төлвийг бүхэлд нь болоод түүний бүрэлдэхүүний мөчлөгийг анхаарах шаардлагатай. Зөвхөн ойрын жилүүдэд чиглэсэн стратеги прогноз хийх нь буруу гэдгийг АНУ-ын жишээ тод харуулж байна, тухайлбал судалгааны төвүүд 2100 он хүртэл прогноз хийж сүүлийн 10 жилийн хугацаанд болсон олон тооны хурлын материал, илтгэлийг судалсан байна. Европын судалгааны төвүүд 2050 он хүртэл прогноз хийдэг бол Хятадын судлаачид 60 жилийн тэртээхийг “харсан” байх жишээтэй. Иймээс ОХУ-ын хувьд мөн иймэрхүү удаан хугацааны прогноз стратегийн төлөвлөгөө шаардлагатай юм.

ОХУ-ын инновацийн хөгжлийн Стратеги

Одоогийн байдлаар санал болгож буй загвар 2050 он хүртэлх прогноз болон 2020 он хүртэлх ОХУ-ын инновацийн хөгжлийн стратеги юм. Энэ 2 хувилбар тодорхой баримт бичгийн хэлбэрээр олон нийтэд

нээлттэй байна. Загварын үндсэн зарчмуудыг ОХУ-ын ШУА, Оросын Нийгмийн ухааны Академийн эрдэмтэд дэмжиж байгаа. Тэдгээрээс нийт улсын хэмжээнд голлох үүрэг гүйцэтгэх зарчмуудыг онцлох нь чухал билээ. Үүнтэй холбоотойгоор янз бүрийн арга зүй, хэрэгжүүлэх механизм зэргийг санал болгож байна. Гол анхаарлаа мэдлэгт суурилсан нийгэмд үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болох шинжлэх ухааны салбарт хандуулах нь чухал бөгөөд ОХУ-д одоогийн байдлаар суурь шинжлэх ухаанд 182, хавсрага шинжлэх ухаанд 200 гаруй, цуврал үйлдвэрлэлд 180, нийтдээ 500-аад тэргүүлэх чиглэл байдаг бол АНУ-д 4, мөн Европд 3 байдаг билээ.

ОХУ-ын 2020 он хүртэлхи инновацийн хөгжлийн Стратегийг ОХУ-ын 2020 он хүртэлхи урт хугацааны хөгжлийн Концепци дээр суурилан 2010 оны 3 дугаар сарын 3-нд хуралдсан Өндөр технологи болон инновацийн засгийн газрын Комиссын хурлын шийдвэрийн дагуу боловсруулсан байна. Уг стратеги 11 бүлэг, 2 хавсралтаас бүрдэж, төр, бизнес, шинжлэх ухаан, боловсрол, хүний капитал, инновацийн дэд бүтэц, инновацийн орчин, хэрэгжүүлэх арга, санхүүжилт зэрэг инновацийн хөгжлийн бүх талыг бүрэн тусгасан баримт болж чадсан гэж үзэж байна.

Уг стратеги инновацийн чадамж, удаан хугацааны шинжлэх ухаан-технологийн прогнозын олон талт судалгааны үнэлгээний дүнд тулгуурлан цаашдаа ОХУ болон түүний зарим хэсэг, бүс нутгуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийн концепци болон хөтөлбөрүүдийн гол чиглүүр болох ёстой.

Энэхүү Стратегийг хэрэгжүүлэхэд юун түрүүнд дараахи зарчмуудыг баримтлах шаардлагатай:

- төрийн чармайлтыг бизнесийн идэвхи сул салбаруудад голчлон төвлөрүүлж, “зах зээлийн уналтыг” нөхөх чиглэлд анхаарал хандуулах;
- технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж тэдгээрийг хэрэгжүүлэх үйл явцад төр, бизнес, шинжлэх ухааны хоорондхи холбоог нягт болгох;
- төсвийн хөрөнгийн хуваарилалт болон гарсан үр дүнгийн үнэлэлтийг тунгалаг болгох;
- шинжлэх ухаан болон боловсролын байгууллагууд болон инновацийн бизнес, инновацийн дэд бүтцийн үр ашгийг дүгнэхэд олон улсын дээд хэмжээний стандартыг баримтлах;

Стратегийн зорилго – 2020 он гэхэд Оросын эдийн засгийг инновацийн хөгжлийн замд оруулах, энэ нь дараахи үндсэн үзүүлэлтээр тодорхойлогдоно:

- 2020 он гэхэд технологийн инноваци хэрэгжүүлэгч бүхий аж ахуйн хувийг 40-50% хүргэх (2009 онд 10,4%);

- Өндөр технологийн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний дэлхийн зах зээлд эзлэх Оросын хувийг 5-7 салбарт 5-10 хувьд хүргэх (үүнд цөмийн эрчим хүч, агаарын техник, сансрын техник болон үйлчилгээ, тусгай хөлөг онгоц гэх мэт);
- Оросын өндөр технологийн бүтээгдэхүүний экспортын хувийн жинг дэлхийн экспортын нийт хэмжээнд 2020 онд 2 хувь хүртэл өсгөх (2008 онд 0,35%);
- 2020 онд ДНБ-нд инновацийн салбарын НӨТ 17-20% хүрнэ (2009 онд 11,8%);
- 2020 онд аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт хэмжээнд инновацийн бүтээгдэхүүний хувийн жинг 25-35 хүртэл хувиар өсгөх (2009 онд 12,4%);
- Судалгаа болон боловсруулалтын дотоодын зардал ДНБ-ний 2,5-3% хүртэл өснө (2009 онд 1,24%), үүний ихэнхийг хувийг сектор гаргана,
- Европын холбоо, АНУ болон Японы патентын газруудад жил бүр бүртгүүлэх Оросын патентын тоо 2020 онд 2,5-3 мянгад хүрнэ (2008 онд 63);
- Их дээд сургуулиудад хэрэгжүүлж буй шинжлэх ухааны судалгааны хувийг 30%-иар өсгөх.

Ингэхдээ эдийн засгийн ерөнхий өсөлт болон инновацийн хөгжлийн хурд хоорондоо улам бүр холбоотой болох ёстой. Нэг талаас инновацийн хөгжил эдийн засгийн бүх салбарт аж үйлдвэрлэлтийн өсөлт, бүтээгдэхүүний өрсөлдөх чадавхийн өсөлт болон зах зээлийн тэлэлт, шинэ салбарууд бий болгох, хөрөнгө оруулалтын идэвхийг нэмэгдүүлэх, хүн амын орлогын өсөлт хийгээд хэрэглээний хэмжээ нэмэгдэх аргаар эдийн засгийн өсөлтийн үндсэн эх үүсвэр болно. 2015 оноос эхлэн инновацийн хөгжил жил бүрийн эдийн засгийн өсөлтийн нэмэгдлийн 0,8% хангах юм. Нөгөө талаас, энэхүү эдийн засгийн өсөлт шинэ бүтээгдэхүүн болон технологи бий болох нөхцлийг хангаж, хүний капитал ба инновацийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж олгож (юун түрүүнд боловсрол болон суурь шинжлэх ухаанд), үүгээр инновацийн хөгжлийн хурд улам нэмэгдэх учиртай.

Инновацийн стратегийн үндсэн зорилтод дараахь зүйл багтана:

1. Шинжлэх ухаан, боловсрол, технологи болон инновацийн салбарт хүний потенциалыг нэмэгдүүлэх, энэ нь ард иргэдийн инновацийн бүтээгдэхүүн болон технологийг хүлээн авах мэдрэмжийг дээшлүүлэхэд оршино. Инновацийн эдийн засагт юун түрүүнд “инновацижсан хүн” чухал учир боловсролын салбарын бүх шатанд үүнд шаардлагатай мэдлэг, дадал, тасралтгүй боловсролын тогтолцоог бий болгож шинжлэх

ухаан, техникийн ололтыг бүрэн ашиглах чадвартайгаас гадна инновацийг буй болгоод зогсохгүй нийгмийн амьдралд түүнийгээ бүрэн ашиглах чадамжтай хүнийг бий болгох зорилт юм.

2. Одоо байгаа бизнесийн инновацийн идэвхийг огцом, эрс нэмэгдүүлж шинээр инновацийн компаниудыг байгуулах. Үүний тулд дэлхийн зах зээлд ОХУ-ын байр суурь, үүргийг тодорхойлдог гол салбаруудын технологийн шинэчлэлийг явуулж, бүх секторт хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх.
3. Төрийн инновацийг нэмэгдүүлэх- төрийн захиргааны байгууллагуудад орчин үеийн инновацийн технологийг нэвтрүүлж, ард иргэдэд үзүүлж буй үйлчилгээг электрон хэлбэрт шилжүүлж, төрөөс инновацийг дэмжих захиалгын системийг өргөжүүлэх.
4. Судалгаа боловсруулалтын тогтвортой хөгжих тогтолцоог байгуулж, дэлхийн зах зээл дээр өрсөлдөхүйц мэдлэгийг өргөжүүлж, шинжлэх ухааны судалгааг арилжааны хэлбэрт шилжүүлэх аргыг улам үр дүнтэй болгох.

Инновацийн хөгжлийг 2 үе шаттай явуулахаар зорьж байгаагаас:

I-р шат (2011-2013 онууд) Орчин үеийн тулгамдсан асуудлуудын нэг нь бизнесийн орчинд инновацийг хүлээн авах чадвар сул, компаниудын стратегид инновацийн үйл ажиллагааны чиг баримжаа доод түвшинд байгаа тул эдийн засгийн ирээдүйтэй өндөр технологийн салбаруудын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулж, эдгээр салбаруудын хөрөнгийн урсгалыг хөхиүлэн дэмжих, өндөр мэргэжлийн боловсон хүчинг татан оруулах, татвар, тариф болон төрийн удирдлагын зохицуулалтын бусад аргуудыг цогцоор нь хэрэгжүүлэх, санхүүгийн төрөл бүрийн дэмжлэг үзүүлэх зэргээр асуудлыг шийдэх зорилт юун түрүүнд тавигдаж байна. Түүнчлэн хувийн компаниудын инновацийн төслүүдийн хөрөнгө оруулалтын зардлын хэмжээг эхний ээлжинд нэмэгдүүлж, одоо ажиллаж буй хөгжлийн институтуудаар дамжуулан гараагаа эхэлж буй компаниудыг (стартап) дэмжих үйл ажиллагааг шинжлэх ухаан-техникийн салбарын жижиг аж үйлдвэрүүдийн хөгжлийг дэмжих Сан, жижиг бизнесийг дэмжих холбооны хөтөлбөрүүд, өндөр технологийн гол салбаруудын тодорхой төслүүдийг дэмжих төрийн хөтөлбөрүүд болон эрчим хүч, цөмийн эрчим хүч, сансрын, радиоэлектроник, онгоцны үйлдвэрлэл гэх мэт салбаруудын хөтөлбөрүүдээр дамжуулан өргөжүүлэх.

Инновацийн хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд Роснано-тех болон Внешэкономбанк, цаашдаа “Сколково” сан голлох үүрэг гүйцэтгэнэ. Ингэхдээ суурь судалгаа болон боловсролын зардлыг хэвээр үлдээж энэ шатанд үр ашгийг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч, шинжлэх

ухааны салбарыг үр ашиг муутай чиглэл, байгууллагаас “цэвэрлэж”, санхүүжилтийн урсгалыг ирээдүйтэй чиглэл болон удирдах боловсон хүчинг шинэчлэхэд хуваарилна. Мөн энэ шатанд муж болон салбарын хүрээнд бизнесийн инновацийн хөтөлбөрүүдийг дэмжих хэд хэдэн төслүүд хэрэгжиж эхлэх бөгөөд үүнд кластерын санаачлага ба технологийн шинэчлэлийг бий болгох зэрэг орно.

Эдийн засгийн шинэчлэлд дараахи зүйл шаадрлагатай:

Төрийн оролцоотой тэргүүлэх компаниуд, их сургууль, холбооны засаг захиргаа, нийтдээ ОХУ-ын бүх субъектын захиргаанд инновацийн хөгжлийн асуудлыг хариуцсан өндөр чадвартай удирдагчдын шинэ давхрагыг бий болгох. Түүнчлэн холбооны болон бүс нутгийн хэмжээнд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эдийн засгийн өндөр технологийн салбарт татан оруулах механизмыг бий болгож, инновацийн бүтээгдэхүүний экспортыг давхар дэмжих бодлого баримтлах.

II-р шат (2014-2020 онууд) Энэ шатанд судалгаа болон боловсруулалтын дотоодын зардлын нийт хэмжээнд хувийн санхүүжилтийн хувь нэлээд өснө. Түүнчлэн боловсрол, шинжлэх ухаан, инновацийн эдийн засгийн дэд бүтцийг шинэчлэхэд ихээхэн хөрөнгө оруулалт хийгдэнэ.

Нэгдүгээр шатанд бий болсон нөөцөд суурилан аж үйлдвэрийн томоохон өөрчлөн шинэчлэл хийгдэх болно. Оросын компаниуд ашиглаж буй технологиор хөгжингүй орнуудын дундаж түвшинд хүрэх агаад үүний тулд хуучирсан технологийн тоног төхөөрөмжийг шинэчлэхийн тулд шаардлагатай татварын болон бусад төрлийн хөнгөлөлтийг үзүүлэх юм.

Энэ шатанд инновацийн дэд бүтцийн үндсэн хэсгүүдийн шинэчлэл болон тэдгээрийн үр ашгийг дээшлүүлэхэд илүүтэйгээр анхаарна. Мөн Оросын инновацийн бүтээгдэхүүн болон технологийг дэлхийн зах зээлд гаргахад илүү дэмжлэг үзүүлж, үүний тулд зээлийн санхүүжилт, шинэ зах зээлд бүтээгдэхүүн гаргах бизнесийн (маркетинг, зөвлөгөө өгөх, үзэсгэлэн зохион байгуулах гэх мэт) зардлыг нэмэгдүүлнэ. Түүнчлэн энэ шатанд ирээдүйн технологийн хөгжилд зарцуулах төсвийн хөрөнгө, технологийн томоохон зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардлын хэмжээ нэмэгдэж төрийн бус санхүүжилт өснө.

Оросын эдийн засагт тогтсон технологийн хөгжлийн чиг, түүний өсөлтийн боломж болон гарах магадлал бүхий эрсдэл инновацийн хөгжлийн стратегийн 3 хувилбарыг буй болгосноос:

1. Импортод чиглэсэн технологийн инерцийн хөгжлийн хувилбар. Уг хувилбар инновацийн хөгжилд чиглэсэн том хэмжээний хөрөнгө оруулалт шаардахгүй, бодлогын гол нь макроэдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж, шинжлэх ухаан, инновацид аль болох бага хэмжээний төсвийн зардал гаргахад чиглэгдэнэ. Иймд үндэсний инновацийн тогтолцоо суларч, эдийн засаг гадаадын

технологиос хэт хараат байдалд орох аюултай. Мөн үндэсний инновацийн тогтолцоо батлан хамгаалах гэсэн хэд хэдэн хэсэгт бутарч дотоодын бизнесийн эрэлт болон төсвийн санхүүжилт буурснаар суурь болон хавсрага шинжлэх ухааны салбар хумигдана. Үүний үр дүнд ОХУ барууны өндөр хөгжилтэй орнуудаас технологийн хөгжлийн хувьд хоцроод зогсохгүй ойрын ирээдүйд инновацийн өрсөлдөөнд Хятад болон шинээр аж үйлдвэржиж буй орнуудаас хоцроход хүргэнэ.

2. Гүйцэх хөгжлийн буюу технологийн өрсөлдөх чадавхийн хувилбар. Уг хувилбар импортын технологийн үндсэн дээр эдийн засгийг шинэчлэхэд чиглээд зогсохгүй дотоодын боловсруулалтын хөгжлийг эрчимжүүлэх юм. Дотоодын технологийн эрэлт хэрэгцээ үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалахын салбарын хэрэгцээг хангаад зогсохгүй эрчим хүч-түүхий эдийн салбарын (цөмийн эрчим хүчний станц, хүнд нөхцөлд газрын тос олборлох технологи гэх мэт) хөгжилтэй мөн холбоотой. Суурь болон хавсрага шинжлэх ухааны салбар зах зээлийн эрэлт хэрэгцээ бүхий чиглэл салбаруудыг тойрон төвлөрнө.

Гүйцэх хөгжлийн замаар хөгжсөн аж үйлдвэржсэн олон орон байдгаас дайны дараах Японоос эхлэн, Өмнөд Солонгос, мөн Зүүн Хойд Азийн орнууд болох Малайз, Сингапур, хамгийн сүүлийн бөгөөд тод жишээ бол Хятад зэрэг орнуудын хөгжлийг тодорхойлсон билээ.

ОХУ-ын хувьд энэ хувилбар дэлхийн зах зээл дээр жирийн боловч оросын стандартад тэргүүлэх зэрэглэлийн технологийг технологийн шинэчлэлийн нэгдүгээр шат болгон олноор нь оруулж ирэхийг нэрийднэ.

Энэхүү стратеги хэд хэдэн давуу талтай, тухайлбал бэлэн бөгөөд сайн боловсрогдсон технологи ашиглаж байгаа тул инновацийн эрсдэл тун бага байх магадлалтай, түүнчлэн инновацийн төслүүдийг богино хугацаанд хэрэгжүүлэх тул эдийн засаг илүү дэвшилтэт технологийг хурдан түгээх боломжтой болно, суурь салбаруудын технологийн хөгжил шинэ өндөр технологийн салбаруудыг бий болгох гэх мэт.

3. Шинжлэх ухаан-техникийн тэргүүлэх салбар болон суурь судалгаанд манлайлалд хүрэх хувилбар. Уг хувилбарын онцлог нь судалгаа-шинжлэх ухаан, зохион бүтээх-туршилт, технологийн болон суурь шинжлэх ухааныг шинэчлэхэд төрөөс чамгүй их чармайлт гарч, тэдгээрийн үр ашгийг дээшлүүлэх, шинжлэх ухаан технологийн чиглэлд үсрэнгүй дэвшил гаргахад хүчин чармайлтаа төвлөрүүлснээр дэлхийн өндөр технологийн бүтээгдэхүүний зах зээл дээр ОХУ-ын байр суурийг дээшлүүлэх юм.

ОХУ сансрын техник, нанотехнологи, композит материал, цөмийн болон ус төрөгчийн эрчим хүч, биоанагаах ухааны технологи болон экологийн зарим салбарт тэргүүлэх байр суурь эзлэх бүрэн боломжтой. Уг хувилбарын дагуу шинжлэх ухааны болон инженерийн

шинэ боловсон хүчний хэрэгцээ эрс өсч, үндэсний инновацийн цогц тогтолцоо бүрэлдэж, Оросын суурь шинжлэх ухаан тэргүүлэх байраа сэргээх боломжтой болох онцлогтой.

Уг зам нь улс төр хийгээд эдийн засгийн талаасаа илүү өгөөжтэй боловч зардал өндөртэй, учир нь суурь судалгааны чиглэлийн судалгаа болон боловсруулалтад төрөөс их хэмжээний зардал шаардагдана.

Том эдийн засагтай орны хувьд ОХУ-д холимог стратеги илүү тохиромжтой. Энэ нь зарим нэг салбарт өрсөлдөх чадавхи бүхий тэргүүлэх стратегийн нэгжтэй, эдийн засаг болон аж үйлдвэрийн ихэнхи салбарт гүйцэх хувилбарыг хослуулахын зэрэгцээ инженерийн болон зохион бүтээх хүчин чадлыг сэргээхийг хэлнэ.

Холимог стратегийн хэрэгжүүлэлт инновацийн бодлогын үндсэн зорилтуудыг тодорхойлно. Юун түрүүнд инновацийн хөгжлийн зарим чиглэлийг дэмжих, инновацийн стратегид нэн шаардлагатай хүний капиталын шинэ шинж чанарыг бүрдүүлэхэд хөрөнгө оруулалт хийхэд төрийн хүчин чармайлт (санхүүгийн болоод зохион байгуулалтын) гол үүрэг гүйцэтгэхийг хэлж буй. Зарим шинжээчид, тухайлбал шинжлэх ухаан, инновацийн хорооны дарга Владимир Гутеневыг үзэж байгаагаар, одоо байгаа нөөцөө ашиглаж, томоохон төсвийн хөрөнгийг маш хатуу хяналтан доор эргэлтэд оруулахын чухлыг онцолж байна. Үүнээс гадна хамтран оролцогч төдийгүй хянах үүрэг гүйцэтгэх бизнесийн хүрээний дэмжлэг мөн шаардлагатай болно. Мөн тэрээр экспортын өндөр потенциал бүхий эдийн засгийн чиглэлүүдийг сонгох шаардлагатай гэж үзэж байгаа. Тухайлбал эрчим хүчний машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, батлан хамгаалахын аж үйлдвэрлэл, онгоцны болон усан онгоцны үйлдвэрлэл зэргийг нэн түрүүнд тавихаар санал болгож байна.

Иймд Оросын засгийн газрын зүгээс инновацийн хөгжлийн замд улс орноо оруулах чармайлт тодорхой баримт бичигтэй болсон нь Стратегийн хөгжлийн концепци билээ.

Стратегийн баримт гаргах болсон явдал дараахь шаардлагаас урган гарсан:

- улсын үндсэн фонд хуучран илэгдэн аюулын хэмжээнд хүрээд байна. Машин, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн ихэнхи нь сүүлийн 15 жилийн хугацаанд шинэчлэгдээгүйн улмаас 60-70% нь өрсөлдөх чадвар бүхий үйлдвэрлэл явуулах боломжгүй болсон тул аль болох богино хугацаанд инновацийн шинэчлэл хийх шаардлагатай юм.
- дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн хуучирч өрсөлдөх чадавхи муутай, дотоодын болон гадаадын зах зээлээс шахагдаж байгаа нь эдийн засгийн түүхий эдийн шинжийг улам нэмж, түлш болон металл, хүнсний

бүтээгдэхүүн, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортоос улам хараат болгож байна. Дэлхий дахинд өрнөж буй технологийн хувьслын эрин үед ийм нөхцөлд дотоодын бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар улам уналтанд орох тул зайлшгүй инновацийн шинэчлэл хэрэгтэй.

- мөн нийгмийн салбарын инновацийн шинэчлэл маш чухал байна, үүнд эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт болон нийгмийн хангамж орно. Ингэснээр хүний капиталын нөхөн үржих нөхцлийг хангаж, хүн амын амьжиргааны түвшин, батлан хамгаалахын салбар хийгээд улс орны болон ард иргэдийн аюулгүй байдлыг дээшлүүлнэ.

Эдгээр зорилтыг биелүүлсэн нөхцөлд 10 жилийн дараа ОХУ-ын ДНБ-ийн хэмжээнд инновацийн сектор 20% хүртэл өсч, дэлхийн оюуны зах зээлийн 10 хүртэлхи хувийг эзлэх боломжтой болох ирээдүй хүлээж буй.

Ашигласан материал:

1. “Проект Стратегии инновационного развития РФ до 2020г.” www.economy.gov.ru/minec/activity/
2. Анастасия Литвинова. “Эксперты раскритиковали стратегию инновационного развития России до 2020г.” www.rbcdaily.ru
3. Б.Н.Кузык. “Россия-2050: стратегия инновационного прорыва”. Москва, 2004.